

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/134/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг  
2023 он

Дарга,  
тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ  
Утас: 70342580  
Цахим хаяг: [Erdeneb@audit.gov.mn](mailto:Erdeneb@audit.gov.mn)  
Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 70342716  
Цахим хаяг: [Enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:Enkhtsoodolj@audit.gov.mn)  
Аудитор: Б.Энхтөр  
Утас: 70342495  
Цахим хаяг: [enkhturb@audit.gov.mn](mailto:enkhturb@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс:7034-2580  
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.08.14 № 57  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ Т

Булган аймгийн Бүрэгхангай  
Сумын Соёлын төвийн Эрхлэгч  
Д.Бат-Өлзий танаа

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

2022 онд байгууллагын батлагдсан төсөв, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хагас жилийн санхүүгийн тайлангийн мэдээ зэрэг 7 мэдээллийг шилэн дансанд хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

### Бусад асуудлын хэсэг

006020061

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 2022 онд 2 зорилтын хүрээнд 32 ажил төлөвлөж гүйцэтгэлийн биелэлт 90 хувьтай дүгнэгджээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>100,000.00</b>	<b>10,261,715.16</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	10,261,715.16
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	-	10,261,715.16
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	10,261,715.16
31211	Төрийн сангийн харилцах	-	10,261,715.16
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>192,586,625.17</b>	<b>188,724,394.95</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	192,586,625.17	188,724,394.95
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	189,774,125.14	184,599,394.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	195,896,553.63	195,896,553.63
39202	Хуримтлагдсан элэгдэл	(40,344,112.90)	(54,176,380.18)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	22,432,701.37	35,806,120.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,600,491.53)	(9,692,751.40)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,132,842.40	10,369,535.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,179,732.83)	(7,540,048.33)
39217	Ном	13,436,365.00	13,936,365.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	2,812,500.03	4,125,000.06
39301	Программ хангамж	1,000,000.00	2,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(187,499.97)	(374,999.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	2,000,000.00	2,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>192,686,625.17</b>	<b>198,986,110.11</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>1,502,110.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	1,502,110.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	1,502,110.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,502,110.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>192,686,625.17</b>	<b>197,484,000.11</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	192,686,625.17	197,484,000.11
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	72,791,726.30	72,791,726.30
51101	Өмч: - төрийн	72,791,726.30	72,791,726.30
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	31,205,173.59	36,002,548.53
51210	Өмнөх үеийн үр дүн	31,205,173.59	31,205,173.59
51220	Тайлант үеийн үр дүн	-	4,797,374.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	88,689,725.28	88,689,725.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>192,686,625.17</b>	<b>198,986,110.11</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>133,732,400.00</b>	<b>123,247,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,945,000.00</b>	<b>13,934,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	6,945,000.00	10,934,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6,945,000.00	10,934,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6,825,000.00	10,934,000.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	3,000,000.00
122001	Хандив тусламж /дотоод/	-	3,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>126,787,400.00</b>	<b>109,313,800.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	800,000.00	300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	800,000.00	300,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	125,987,400.00	109,013,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	125,987,400.00	109,013,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>153,030,199.45</b>	<b>118,350,425.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>153,030,199.45</b>	<b>118,350,425.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	121,551,783.06	117,176,836.06
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	49,229,062.00	46,981,397.00
210101	Үндсэн цалин	37,839,333.00	41,817,482.00
210102	Нэмэгдэл	-	3,622,841.00
210104	Урамшуулал	-	1,541,074.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6,681,415.61	5,873,243.84
210201	Тэтгэврийн даатгал	4,657,261.64	4,265,984.78
210202	Тэтгэмжийн даатгал	528,141.67	506,528.33
210203	ҮОМШӨ-ний даатгал	397,535.28	381,736.13
210204	Ажилгүйдлийн даатгал	99,588.72	65,363.09
210205	Эрүүл мэндийн даатгал	998,888.30	653,631.51
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,062,276.00	36,799,665.00
210301	Гэрэл, цахилгаан	214,716.00	450,055.00
210302	Түлш, халаалт	34,847,560.00	36,349,610.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	7,100,792.00	634,600.00
210401	Бичиг хэрэг	151,200.00	223,000.00
210402	Тээвэр, шатахуун	187,230.00	236,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	50,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	54,500.00	50,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	890,000.00	286,500.00
210604	Урсгал засвар	850,000.00	286,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	56,000.00	174,000.00
210702	Дотоод албан томилолт	56,000.00	174,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,029,400.00	3,856,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,029,400.00	3,856,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19,457,837.45	22,571,230.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	550,000.00	2,775,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	18,907,837.45	19,796,230.22
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	31,478,416.39	1,173,589.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	28,801,800.00	760,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	760,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	2,676,616.39	413,589.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,676,616.39	413,589.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(19,297,799.45)</u></b>	<b><u>4,897,374.94</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	100,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	100,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(100,000.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(19,297,799.45)</u></b>	<b><u>4,797,374.94</u></b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

#### МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>126,907,400.00</u></b>	<b><u>109,313,800.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>126,787,400.00</b>	<b>109,313,800.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	800,000.00	300,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	800,000.00	300,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	125,987,400.00	109,013,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	125,987,400.00	109,013,800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>126,657,400.00</u></b>	<b><u>99,023,984.84</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>126,657,400.00</b>	<b>99,023,984.84</b>

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>95,178,983.61</b>	<b>97,378,495.84</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	49,128,410.00	46,907,397.00
210101	Үндсэн цалин	37,738,681.00	41,743,482.00
210102	Нэмэгдэл	-	3,622,841.00
210104	Урамшуулал	-	1,541,074.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6,782,067.61	5,873,243.84
210201	Тэтгэврийн даатгал	4,757,913.64	4,265,984.98
210202	Тэтгэмжийн даатгал	528,141.67	506,528.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	397,535.28	381,736.13
210204	Ажилгүйдлийн даатгал	212,724.50	65,363.09
210205	Эрүүл мэндийн даатгал	885,752.52	653,631.51
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	35,062,276.00	35,297,555.00
210301	Гэрэл, цахилгаан	214,716.00	450,055.00
210302	Түлш, халаалт	34,847,560.00	34,847,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	322,230.00	708,600.00
210401	Бичиг хэрэг	60,000.00	297,000.00
210402	Тээвэр, шатахуун	98,030.00	197,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	89,200.00	88,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	50,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	930,000.00	286,500.00
210604	Урсгал засвар	300,000.00	286,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	56,000.00	174,000.00
210702	Дотоод албан томилолт	56,000.00	174,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,898,000.00	5,956,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,898,000.00	5,956,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	-	2,175,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,175,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,478,416.39</b>	<b>1,645,489.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	28,801,800.00	760,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200,000.00	760,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	2,676,616.39	885,489.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,676,616.39	885,489.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>250,000.00</u></b>	<b><u>10,289,815.16</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,250,000.00</b>	<b>500,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,250,000.00</b>	<b>500,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,250,000.00	500,000.00
223001	Бусад хөрөнгө	1,000,000.00	500,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(1,250,000.00)</u></b>	<b><u>(500,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	(1,000,000.00)	9,789,815.16
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	10,261,715.16

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,791,726.30	88,689,725.28	49,502,973.04	210,984,424.62
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,791,726.30	88,689,725.28	49,502,973.04	210,984,424.62
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(18,297,799.45)	(18,297,799.45)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,791,726.30	88,689,725.28	31,205,173.59	192,686,625.17
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	72,791,726.30	88,689,725.28	31,205,173.59	192,686,625.17
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	72,791,726.30	88,689,725.28	31,205,173.59	192,686,625.17
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	4,797,374.94	4,797,374.94
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	72,791,726.30	88,689,725.28	36,002,548.53	197,484,000.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	111095800.00	98638495.84
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	111095800.00	98138495.84
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	111095800.00	97378495.84
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	54697900.00	46907397.00
210101	Үндсэн цалин	51937400.00	41743482.00
210102	Нэмэгдэл	2760500.00	3622841.00
210104	Урамшуулал	0.00	1541074.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	6837300.00	5873243.84
210201	Тэтгэврийн даатгал	4649400.00	4265984.98
210202	Тэтгэмжийн даатгал	546900.00	506528.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	437700.00	381736.13
210204	Ажилгүйдлийн даатгал	109400.00	65363.09

210205	Эрүүл мэндийн даатгал	1093900.00	653631.51
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35697600.00</b>	<b>35297555.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	450100.00	450055.00
210302	Түлш, халаалт	35247500.00	34847500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1212000.00</b>	<b>708600.00</b>
210401	Бичиг хэрэг	297000.00	297000.00
210402	Тээвэр, шатахуун	200000.00	197900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,000.00	75,000.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	90,000.00	88,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50,000.00	50,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>575,000.00</b>	<b>286,500.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	175,000.00	-
210604	Урсгал засвар	400,000.00	286,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>458,000.00</b>	<b>174,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	458,000.00	174,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,968,000.00</b>	<b>5,956,200.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,968,000.00	5,956,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>5,650,000.00</b>	<b>2,175,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,650,000.00	2,175,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>109,785,700.00</b>	<b>109,013,800.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>109,785,700.00</b>	<b>109,013,800.00</b>
132001	Орон нутгийн төсвөөс	109,785,700.00	109,013,800.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бүрэгхангай сумын Соёлын төв нь “Төрөөс баримталж байгаа соёлын бодлогыг хэрэгжүүлж, соёл урлагийн байгууллагуудын материаллаг бааз, боловсон хүчний хангамж, чадамжийг дээшлүүлэн, иргэдийн оюуны хэрэгцээг хангах, орон нутагт хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд 6 зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Иргэдийн хүсэл сонирхолд нийцүүлэн ажиллах
- Хөдөөгийн хүн амд соёлын үйлчилгээ, Явуулын номын сан мэдээллийн үйлчилгээг жигд хүртээмжтэй тогтмол чанартай хүргэх
- Номын сангийн стандартыг мөрдөж бүрэн хангах
- Үзэгч, уншигчдын тоог 25 хувиар нэмэгдүүлэх

- Мэргэжлийн боловсон хүчний хангалтыг 100% хүргэх
- Урлагийн хувцас, Хөгжим техник хэрэгсэл, Автомашинаар бүрэн хангагдах зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монгол улсын үндсэн хууль, Соёлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын тухай хууль, холбогдох тогтоол шийдвэр, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулж, хэрэгжилт нь үр нөлөөтэй байна.

Дотоод аудит, аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Бүрэгхангай сумын Соёлын төв нь дотоод аудит, аудиторгүй дотоод хяналт шалгалтын бүрэлдэхүүнтэй хяналт нь өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаж байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэгхангай сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүрэгхангай сумын Соёлын төв нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 66.3 сая төгрөгөөр буюу 9 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	10,261,715.16	10,261,715.16
Авлага	0	0	0
Бараа материал	100,000	0	100,000
Үндсэн хөрөнгө	192,586,625.17	188,724,394.687	3,862,230
<b>Нийт хөрөнгө</b>	<b>192,686,625.17</b>	<b>198,986,110.03</b>	<b>(6,299,485)</b>
Өр төлбөр	0	1,502,110	1,502,110
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	72,791,726.3	72,791,726.3	0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>192,686,625.17</b>	<b>198,986,110.03</b>	<b>(6,299,485)</b>

Дээрх хүснэгтээс харахад, 2022 он өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө дансны талаар товч тайлбарлан бичнэ.

Өмнөх онд мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлгүй байсан бол тайлант онд 10.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой зардал бага гарснаар хэмнэлт үүссэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Улсын төсвөөс 125.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 125.6 сая төгрөгөөр өгсөн боловч тус саналаас зардлыг 73.2 сая төгрөгөөр бууруулж, орон нутгийн данснаас 37.5 сая төгрөг баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч тоног төхөөрөмж худалдан авах буюу үндсэн хөрөнгө бэлтгэх зардлаас хасаж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тухайн тайлант онд тус байгууллагын төсөвт тодотгол хийгдээгүй байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 70.7 сая төгрөгийн санхүүжилт олгож, 60.5 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулан төсвийн гүйцэтгэл 85% гүйцэтгэлтэй байна. Тайлант оны эцэст 10.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна. Орон нутгаас 39 сая төгрөгийн санхүүжилт олгож 38.6 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулан 431.5 мянган төгрөгийн санхүүжилт төвлөрүүлэн шилжүүлж ажиллажээ. Төсвийн гүйцэтгэл 98 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын 98 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 431.5 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал /80101/	65,857.3	56,206.5	9,650.8	85
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж /80802/	768,0	760,0	8	98,9
3	Дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/	3650,0	500,0	3150,0	13
4	Төрийн өмчийн барилгын зардалд /80111/	35697,6	35284,0	413,5	98,8
5	Нийтлэг үйлчилгээний зардал /80112/	2590,9	2546,9	44	99,9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бүрэгхангай сумын Соёлын төв нь 2022 оны санхүүгийн тайлангаар нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ хийгдээгүй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

#### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

Бүрэгхангай сумын Соёлын төвд тайлант онд төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

#### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүрэгхангай сумын Соёлын төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитор Б.Энхтөр гүйцэтгэж, хяналтыг Аудитын менежер Ж.Энхцоодол, Дарга, Тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүрэгхангай сумын Соёлын төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/01 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 1.5 хувиар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны бусад 98.5 сая төгрөгөөс 80 хувиар буюу 1.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага алба хаагчдын хурал цуглаан, сургалт семинарыг цахимаар зохион байгуулж үүнээс албан томилолтын зардал, шатахууны зардлыг хэмнэж мөн байгууллагын дотоод сүлжээг ашиглаж байгууллагын бичиг хэргийн зардлыг өмнөх оноос 469.9 мянган төгрөгөөр хэмнэсэн зэрэг арга хэмжээ авч ажиллажээ.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

2022 онд Байгууллагын батлагдсан төсөв, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хагас жилийн санхүүгийн тайланг шилэн дансанд 7 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Томилолтоор явсан анхан шатны баримтын бүрдэлгүй батлагдсан төсвийн зориулалт бус зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүй.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Бүрэгхангай сумын Соёлын төвийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Бүрэгхангай сумын Соёлын төв нь өмнөх аудитаар 2 зөвлөмж 1 төлбөрийн акт тогтоож энэ хүү зөвлөж, төлбөрийн актын биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 22-ний өдрийн 01/07 тоот албан бичгээр тогтоосон хугацаанд биелэлтийг хангаж ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	447,972	1	447,972	100
Албан шаардлага	0	0	0	0	0
Зөвлөмж	2	100,652	2	100,652	100
<b>Нийт дүн</b>	<b>3</b>	<b>548,624</b>	<b>3</b>	<b>548,624</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад жилийн эцсийн төвлөрүүлсэн орлогыг санхүүгийн тайланд данс андуурч бүртгэсэн 413.6 мянган төгрөгийн бичилтийн алдааг<sup>1</sup> залруулсан.

Аудитаар нийт 24.7 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 24.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Үүнээс хууль хяналтын байгууллагат шилжүүлсэн, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлээгүй байна.

### 5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

### 5.2 Албан шаардлага бичигдээгүй

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Анхан шатны баримтгүй 24.7 мянган төгрөгийн хэвлэлийн зардал гаргасан.

##### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

#### 2. Шилэн данстай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Тайлант онд шилэн дансны 7 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн

##### Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бүрэгхангай сумын Соёлын төв	2	24.7	0	0	0	0	2	24.7				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>24.7</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>2</b>	<b>24.7</b>				